

ТҮҮХ, ЭДИЙН ЗАСАГ, СОЁЛ

**ҮНДЭСТНИЙ РАЙОНУУДАД ЯВУУЛЖ БАЙГАА
ХЯТАДЫН УДИРДЛАГЫН ЭДИЙН ЗАСГИЙН
БОДЛОГЫН ЗАРИМ АСУУДАЛ (1979--1984)****Ц. Батбаяр**

БНХАУ байгуулагдсаны дараах эхний жилүүдэд Хятадын удирдлага үндэсний районуудын эдийн засгийг өөд татах явдлыг Хятадын хятад биш ард түмнүүдийн бодит байдал дээрх тэгш бус байдлыг арилгах нэг чухал арга хэмжээ гэж үзэж байв. Үндэсний зах хязгаарын эдийг засгийг хөгжүүлэх чиг шугамыг баримталсан болон энэ үйл хэрэгт ЗХУ, БНМАУ, социалист бусад орон бодитой туслалцаа үзүүлсний үр дүнд 1957 оны эцэс гэхэд ихэнх үндэсний районд орчин үеийн аж үйлдвэрийн суурь тавигдаж, зам харилцаа хөгжин, хөдөө аж ахуйд газрын шинэчлэлт хийгдэж байв.¹

Гэтэл 50-иад оны эцэс, 60-аад оны эхээр Хятадын удирдлага энэ чиг шугамдаа огцом эргэлт хийсэн билээ. ЗХУ болон социалист хамтын нөхөрлөлийн бусад оронтой хамтран ажиллахаас татгалзаж, үндэстний районуудын эдийн засгийн хоцрогдсон байдлыг аажмаар даван туулахыг заасан ХКН-ын VIII их хурлын шийдвэрээс ухаарч үндэсний районуудыг зөвхөн газар тариалан, аж үйлдвэрийн түүхийн эдийн эх булаг гэж үзэх болов. 60-аад оноос явуулж ирсэн «хилийн районы» бодлого нь үндэстний районуудын эдийн засгийн амьдралын бүх салбарыг цэрэгжүүлэхэд чиглэж материаллаг үйлдвэрлэлд армийн үүрэг роль улам өсөж ирэв. Энэхүү маоист бодлогын уршгаар Хятадын үндэстний районуудын эдийн засгийн хөгжил зогсонги байдалд оржээ. Тухайлбал Хятадын аж үйлдвэрийн үйлдвэрлэлд үндэстний районуудын эзлэх хувийн жин 1957-оос 1975 онд өчүүхэн өссөн бөгөөд 1965 оноос эхлэн нэг төвшинд хэвээр байсаар иржээ.²

Ийнхүү БНХАУ байгуулагдаад 30 гаруй жил болж байхад хятад биш ард түмний амьдралын төвшин тун доогуур, хятад мужуудтай харьцуулахад үндэстний районуудын хоцрогдол асар их байгааг Хятадын суртал нэвтрүүлгийн хэрэгслүүд ч хүлээн зөвшөөрөхөд хүрчээ. Үндэстний районууд нийлээд Хятадын аж үйлдвэрийн бүтээгдэхүүн дөнгөж 8%-ийг үйлдвэрлэж байга нь дан ганц Шанхай хотын аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 63,3% болж байна.³ Түүнчлэн БНХАУ-ын 1 хүнд ноогдох аж үйлдвэр—хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн дунджаар 670 юань байхад таван ӨЗО-ын 1 хүнд зөвхөн 390 юань ноогдож байна.⁴

1. В. И. Потапов. Экономическая политика руководства КНР в национальных районах. в. кн. «Маоизм и национальный вопрос» УБ., 1980. с. 132.
2. «Проблемы Дальнего Востока», 1981. № 4. с. 99.
3. «Гуанмин жибао», 1981. 1. 31
4. «Миньцзу туаньцзе», 1982. № 5. 16-р тал.

1979 оны 5, 6-р сард Тяньцзинд болсон БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан дээр «хан үндэстний олон тооны хүн ам, түүний техникийн давуу байдлыг үндэстний цөөхний өргөн уудам дэвсгэр нутаг, түүний байгалийн баялагтай холбон нэгтгэхийн»⁵ чухлыг онцлон тэмдэглэсэн нь санамсаргүй зүйл биш юм. Хятадын албан ёсны тоо бүртгэлээр БНХАУ-ын хүн амын 6,7% буюу 67 сая хятад биш ард түмэн оршин суудаг Өвөр Монгол, Синьцзян, Төвд, Нинся, Гуанси, Хөхнуур, Юаньнань, Гуйчжоу ба Гуандун зэрэг өөртөө засах орон, мужууд нийлээд БНХАУ-ын бүх газар нутгийн 60% орчмыг эзэлдэг ажээ. Энэхүү уудам газар нутагт Хятадын бэлчээрийн 90%, ойн нөөцийн 46%, усны нөөцийн 52% байгаагаас гадна нүүрсний 40%, фосфорын 33% зэрэг ашигт малтмалын асар их баялагтай ажээ.

Дээрх «холбон нэгтгэх» бодлогынхоо дагуу сүүлийн жилүүдэд Хятадын удирдлага эдийн засгийн хувьд Хятадын томхон хот, мужууд болон үндэстний районуудын хооронд эдийн засаг—техникийн талаар «хамтран ажиллахыг» чухал ач холбогдолтой гэж үзэж, үүнийг зүйл бүрээр дэмжиж байна. 1979 оноос эхэлсэн энэ «хамтын ажиллагаа» нь үндэстний районуудад хамтарсан үйлдвэрийн газар байгуулах, тэндхийн байгалийн баялгийг хамтын хөрөнгөөр олзворлоход голчлон чиглэгдэх болов. Хятадын 8 муж, ӨЗО-ны бүрэн бус мэдээнээс үзвэл тэдний хооронд 1980-аас 1982 онд эдийн засаг—техникийн «хамтын ажиллагааны» 1178 объект төлөвлөсөнөөс 1982 оны эцэс гэхэд 381 объектыг ашиглалтад өгч, 663 объектыг барьж байна гэж Хятадын хэвлэлд бичжээ.⁶ Энэхүү объектуудын ихэнх нь үндэстний районууд дахь эрчим хүчний нөөц баялгийг хамтын хүчээр олзворлох зориулалттай бөгөөд уул районуудын биш, харин хүн ам олонтой, аж үйлдвэр хөгжсөн Хятадын хот, мужуудын өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангахад үйлчилж байгаа нь анаарал татаж байна.

Тухайлбал ӨМӨЗО-ны Хөх хот болон Цзянсу мужийн Уси хотын хооронд байгуулсан «хамтран ажиллах» гэрээ ёсоор 1982 оноос 1984 оны хооронд Уси хот Хөх хотод 5 сая юаний хүүгүй зээллэг олгох ба Хөх хот хариуд нь Уси хотод жил бүр 100 мянган тонн нүүрс нийлүүлэхээр тохиролцжээ.⁷

1981 оны 10-р сард Хөх хотод болсон Хойд Хятадын таван муж, хот, ӨЗО-ны эдийн засаг—техникийн «хамтын ажиллагааны» зөвлөлгөөн дээр ӨМӨЗО-д нийт 34 сая юаний төсөвтэй 12 хамтарсан объект барих хэлэлцээрт гарын үсэг зуржээ.⁸ Энэхүү объектуудын дийлэнх нь ашигт малтмалын арвин баялагтай бөгөөд нүүрсний нөөцөөр Хятадад 2-т ордог Өвөр Монголын өнгөт биш металлыг олзворлох, нүүрсний уурхайнуудыг өргөтгөх, ойн баялаг нөөцийг нь ашиглах зэргийг хамарч байгаа ажээ. Ер нь Өвөр Монголын хүн ам өргөн хэрэгцээт бараагаар гачигдаж байдаг нь бусад мужуудтай хийж байгаа солилцооноос илэрхий байна. Зөвхөн 1981, 1982 онуудад хөнгөн аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг нүүрсээр солих зэргээр ӨМӨЗО-оос бусад 6 мужуудтай хийсэн эд материалын солилцоо 270 сая юаньд хүрчээ.⁹

1983 оны 5, 6-р сар гэхэд Синьцзян—уйгарын ӨЗО-оос бусад муж, хотуудтай «хамтран ажиллах» 126 хэлэлцээрт гарын үсэг зуржээ. «Энэ нь бусад хөгжингүй газруудтай технологийн тусламжтайгаар Синьцзяны баялаг нөөцийг олзворлон ашиглах замаар энэхүү

5. APBM KHP M, 1980, с. 142.

6. «Синьхуа Юэбао», 1983. № 10. 109-р тал.

7. «Миньцзу туаньцзе», 1982. № 7. 14-р тал.

8. Мөн тэнд. № 4, 13-р тал.

9. «Чайна дейли», 1983. XI. 11.

стратегийн хувьд чухал хилийн районыг хөгжүүлэх хүчин чармайлтын нэг хэсэг» гэж англи хэл дээр гардаг «Чайна дейли» сонин бичжээ. Энэ зорилгоор сүүлийн жилүүдэд Хятадын эдийн засгийн харьцангуй хөгжилтэй төвийн муж хотуудаас олон тооны тусгай мэргэжилтэй техникийн ажилтанг Синцзянд явуулжээ. Хөдөө аж ахуйн сэлбэгийн ба нэхмэлийн үйлдвэрүүдийг ажилчдын хамтаар Шанхай, Ланьчжоу зэрэг хотоос нүүлгэн Синьцзы хотуудад байрлуулжээ.

Энэхүү «хамтын ажиллагаанд» сүүлийн үед Төвдийн ӨЗО-ыг татан оруулж байна. Хятадын Төрийн Зөвлөл болон Шанхай, Тяньцзинь, Сычуань, Чжэцзяны төлөөлөгчид Лхаст очиж газар дээр нь судлан хэлэлцээ хийсний дүнд эрчим хүч, зам харилцаа, геологи хайгуулын талаар «хамтран ажиллах» 70 төсөлд гарын үсэг зуржээ.¹⁰ Энэ нь бусад үндэстний районуудтай харьцуулахад бага судлагдсан Төвийн ашигт малтмалын орд газрыг нээж ашиглах зорилготой ажээ. Мөн Хятадын хэвлэлд мэдээлснээр 1984 оны эхээр Төвдийн ӨЗО-ы төв Лхас хотод зочид буудал, хүүхдийн ордон, дээд сургууль үйлдвэр усан хангамжийн систем зэрэг барилга байгууламж барихаар Хятадын 9 муж, хотоос 4000 гаруй мэргэжилтэй техник ажилчид Төвдөд очоод байгаа ба эдгээр барилгыг 1985 оны 8-р сард дуусгах ажээ.¹¹ Ийнхүү 1979 оноос эхлэн БНХАУ-ын үндэстний районууд болон эдийн засаг, техникийн тал бүрийн «хамтын ажиллагааг» эрс өргөжүүлэх бодлого явуулж байгаа нь тодорхой байна. Гэхдээ энэ нь үндэстний районуудад оршин суудаг хятад биш ард түмний үндсэн эрх ашигт нийцүүлэн тус районуудын аж үйлдвэр, хөдөө аж ахуйг хөгжүүлэхэд чиглэгдэж байна гэхээс хятад мужуудын түүхий эдийн хавсарга болон ашиглахад чиглэгдэж байгаа хандлага илүү ажиглагдаж байна.

Гадаадтай Хятадын харилцах «нээлттэй хаалтын» бодлогын дагуу үндэстний районуудад гадаадын капитал нэвтэрч байна. ӨМӨЗО-ы хувьд авч үзвэл 1980 оноос эхлэн Япон, Английн фирмүүдтэй хамтран хөнгөн аж үйлдвэрийн, түүний дотор ноос, ямааны ноолуур боловсруулах, нийт 6 объект барьсан тухай Синьхуа агентлаг мэдээлжээ.

Синьцзян—уйгурын ӨЗО нь Япон, Кувейт, Итали, Австрали, ХБНГУ, АНУ, Гонконгийн хөрөнгөтнүүдтэй хамтран 100 сая ам долларын хөрөнгө оруулалттай 22 объектыг барьж байгуулах хэлэлцээ хийж байгаа ажээ.¹² Үүнд ус районы байгалийн баялаг нөөцийг олзворлон өнгөт биш ба ховор металл, нэхмэл эдлэл, малын тэжээл үйлдвэрлэх объектууд багтаж байна. Түүнчлэн тус ӨЗО нефть, нүүрс, хүнсний давс боловсруулах үйлдвэрүүд байгуулахад гадаадын капиталыг өргөнөөр татан ашиглахаар төлөвлөж байна. 1983 оны 5-р сард Кувейт улс Урумчид химийн бордооны томоохон үйлдвэр барихад туслалцаа үзүүлэхээр болжээ. Үндэсний районд гадаадын капиталыг өргөн нэвтрүүлж байгаа нь БНХАУ-ын улс ардын аж ахуйг хөгжүүлэхэд гадаадтай ялангуяа өрнөдтэй хийх гадаад эдийн засгийн харилцааны хөшүүргийг идэвхтэй ашиглах гэсэн Хятадын удирдлагын бодлогын нэг хэсэг юм.

Үндэстний районуудын байгалийн баялгийг озворлон ашиглах явдалд тэндхийн зам тээврийн харилцааны хоцрогдмол байдал гол саадын нэг болж байгаа ажээ. Жишээлбэл Нинся, Өвөр Монгол, Юнь-

10. Мөн тэнд. 1983. XI. 5

11. Мөн тэнд. 1984. VI. 17.

12. «Чайна дейли», 1983. V. 20.

нань, Гуйчжоу зэрэг үндэсний районууд нүүрсний арвин их нөөцтэй боловч тэндээс бусад мужууд руу зөөвөрлөх зам харилцаа муу хөгжсөн нь нүүрс олзворлолын хэмжээг хязгаарлаж байна гэжээ. Ялангуяа Синьцзян—Уйгурын ӨЗО-д зам харилцааны хоцрогдол ноцтой асуудал болж байна.

Нөгөө талаас үндэстний районууд мэргэжилтэй боловсон хүчин, инженер—техникийн ажилтнаар үлэмж дутагдаж байна. Өнөөгийн байдлаар үндэсний районуудад ажиллаж байгаа нийт 500 мянган инженер—техникийн ажилтнууд өсөн нэмэгдэж байгаа шаардлагыг хангахгүй байна гэж «Бээжин ревью» сэтгүүл бичжээ. Ялангуяа тэдний дунд үндэсний боловсон хүчний эзлэх хувийн жин өчүүхэн байна. 1980 оны байдлаар үндэстний районуудад үндэсний инженер—техникийн ажилтан 82700 ажиллаж байснаас тэдний дотор дээд, дунд техникийн боловсролтой хүн 2203-аас хэтрэхгүй буюу дөнгөж 2,66%-ийг эзэлж байжээ.¹³ Энэ нь юунд хүргэж байгааг ӨМӨЗО-д баригдаж байгаа Холинхэгийн нүүрсний ил уурхайн жишээн дээр авч үзжээ.¹⁴ Тус уурхай 1978 оноос хойш 200 юанийн үнтэй 817 нэр төрлийн тоног төхөөрөмж гадаадаас импортоор авчээ. Гэтэл тус объектын 7 удирдах тушаалтны нэг нь техникийн мэргэжил үгүй, тэр ч байтугай ерөнхий инженер байхгүй зэрэг техникийн мэргэжилтний дутагдлаас болж импортласан тоног төхөөрөмжийн дөнгөж 37,2%-ийг зохих нөхцөлд хадгалж чаджээ. Иймэрхүү үзэгдэл үндэсний районуудад бараг нийтлэг гэж Хятадын хэвлэлд тэмдэглэжээ.

Иймд Хятадын удирдлага дээд сургууль, техникийн тусгай мэргэжлийн сургууль төгсөгчдийг үндэсний районд олноор илгээх, төгсөөд тэнд очиж ажиллах оюутнуудад зориулан их, дээд сургуульд тусгай анги нээх, үндэстний районуудад ажиллаж байгаа инженер—техникийн ажилтнуудын цалин урамшлын шинэ систем боловсруулах, ялангуяа Төвд—Хөх нуурын өндөрлөгийг онцгой анхаарч, тэнд очиж ажиллагсад 8 жилийн дараа эрэг хавийн болон төвийн мужид буцаж болох, хэrvээ тэнд үлдвэл цалингийн нэмэгдэл олгох зэрэг арга хэмжээ авахаар төлөвлөжээ. Үүний дунд сүүлийн жилүүдэд үндэстний районд шилжиж очиж байгаа хятад иргэдийн бүрэлдэхүүнд техникийн мэргэжилтэй боловсон хүчний хувийн жин нэмэгдэх хандлагатай байна.

Сүүлийн жилүүдэд БНХАУ-ын үндэстний районууд Хятадын хэвлэлийн анхаарлын төвд байв. 1983 оны 7, 8-р сард ХКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Ху Яобан Хөх нуур, Ганьсу мужаар, Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд Жао Зыян ӨМӨЗО-ы Хөлөнбуйр, Синьцзян—Уйгурын ӨЗО-оор, 1984 оны 9-р сард Ху Яобан Өвөр Монголын зарим нутгаар явав. Хятадын удирдагчид хэлсэн үгэндээ нэг талаас үндэстний «нэгдэл нягтралыг» зузаатгах, нөгөө талаас үндэстний эдийн засгийн бүтээн байгуулалтыг түргэтгэхийг чухалчилжээ. Тэд ХХ зууны эцэс—ХХI зууны эх гэхэд Хятадын эдийн засгийн бүтээн байгуулалтын голыг Баруун Хойд Хятадад шилжүүлэх стратегийн зорилтыг дэвшүүлэв. Энэ нь зүйл биш бөгөөд бүр 1954 онд Хятадын хэвлэлд «одоогийн Зүүн Хойд Хятадыг Үйлдвэрлэлийн хүчин чадлаар давж гарах тийм томоохон аж үйлдвэрийн баазыг Баруун Хойд Хятадад байгуулах болно» гэж бичиж байжээ.¹⁵

Мөн Ху Яобан, Жао Зыян нар үндэстний районуудад мал аж ахуйн түүхий эдийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх урьдчилсан нөхцөл

13. «Миньцзу Туаньцзе», 1982. № 7. 27-р тал.

14. «Бээжин ревью», вол. 26. № 41. р. 23-24.

15. «Маоизм и национальный вопрос», УБ., 1980. с. 130.

нь тэнд «бэлчээрийн ургамал, мод тарих» явдал гэж тодорхойлжээ. Энэ нь Хятадын ойн нөөцийн 46% байдаг үндэстний районуудын үнэт баялгийг шинжлэх ухааны үндэсгүй, хайр гамгүй ашигласантай холбоотой юм. Түүнчлэн Хятадын нийт бэлчээрийн 90% гаруй байдаг үндэстний районуудад бэлчээр элсэнд идэгдэж, сүйдэх явдал маш их газар авчээ. ӨМӨЗО-д удаан хугацааны туршид үр тариаг голчлон хөгжүүлэх өрөөсгөл бодлого явуулж, бэлчээрийг их хэмжээгээр хагалбарласны уршгаар элсэнд идэгдсэн газрын талбай 110 сая му-гаас (1 = 1/15 га) давсан ажээ.¹⁶ Синьцзяны Таримын өмнөд хэсэгт гэхэд л хүмүүсийн зохисгүй үйл ажиллагаанаас болж 14 мянган км² газрын ургамал сүйдэж тариалангийн талбай, хадлан, бэлчээр элсэнд хучигдажээ.¹⁷ Үүнээс үзвэл Хятадын мал аж ахуй үндсэн районууд болох Өвөр Монгол, Синьцзян, Хөх нуур, Төвдөд бэлчээр, ойн нөөцийг нөхөн сэргээх, хамгаалах, зөв ашиглах явдал ноцтой асуудал болж байгаа ажээ.

1983 оны 12-р сард БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Хятад биш үндэстний үйлдвэрлэл ба амжиргааны асуудлаархи хурлыг Бээжинд зарлан хуралдуулав. Тус хурлыг хуралдуулах болсон шалтгаан нь Төрийн Зөвлөлийн ерөнхий сайдын орлогч Тянь Цзюнийн хэлсэн үгнээс тодорхой байна. Тэр үндэстний районуудыг эрэг хавийн ба төвийн районуудтай харьцуулахад урьдын адил маш их хоцрогдонгуй, зарим районы хүн ам хувцас, хүнс, орон сууц, ундны ус зэрэг хамгийн наад захын амьдралын нөхцөлөөр гачигдаж байгааг тэмдэглэжээ.¹⁸ Тус хуралтай холбогдуулан «Жэньминь жибао» сонины тэргүүн өгүүлэлд бичихдээ, улсын тусламж, бусад муж, хошуудын тал бүрийн туслалцаа үндэстний районы эдийн засгийг хөгжүүлэх чухал нөхцөлүүд боловч шийдвэрлэгч хүчин зүйл бол тэд «өөрсдийн хүчинд тулгуурлах явдал» гэж бичжээ.¹⁹

70-аад оны сүүлч 80-аад оны эхээр БНХАУ-ын үндэстний районуудын талаар ХКН-ын удирдлагаас явуулж байгаа эдийн засгийн бодлогын эцсийн үр дүнд юунд чиглэсэн бэ гэсэн асуулт зүй ёсоор гарч байна. Үндэстний районуудын ихэнх нь Хятадын «хилийн районууд» гэж тооцогддог. Хятадын удирдагчид эдгээр районыг «Хятадын батлан хамгаалалтанд стратегийн тун чухал байр суурь эзэлдэг» гэдгийг нэн түрүүнд чухалчилж байна.

«Дөрвөн шинэчлэлтийн» бодлого, ялангуяа ХКН-ын XII их хурлаас дэвшүүлсэн ХХ зууны эцэс гэхэд Хятадын аж үйлдвэр-хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүнийг 4 дахин нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлэхэд үндэстний районуудын эдийн засгийн нөөц бололцоог хамгийн дээд зэргээр дайчлан ашиглах явдал хятадын удирдлагын бодлогод чухал байр эзэлж байна. Үндэстний районуудын эдийн засгийн уналтын байдалд, үндсэн хүн амын амьдралыг ядууралд хүргэсэн «соёлын хувсгалын» уршигт үр дагавар нь үндэстний районуудын өвөрмөц онцлогийг үл хайхрах, хятад мужуудын арга барилыг шууд хуулбарлан хэрэглэдэг зарим хэт явцгүй зүйлийг хянан завсарлахад хүргэжээ. Гэвч «үндэстний районы байгалийн баялгийг хятад үндэстний хөгжилтэй, технологтой холбон нэгтгэх» нэрийн дор үндэстний районуудын түлш, түүхий эдийн нөөцийг Хятадын бусад хот, мужуудын хэрэгцээнд үйлчлүүлэх бодлого явуулж байгаа нь үндэстний районуудын хятад биш ард түмний үндсэн эрх ашгийг хохирооход хүргэж болох юм.

16. «Жэньминь жибао», 1983. X. 7

17. «Миньцзу яньцзу», 1982 № 2. 7-р тал.

18. «Жэньминь жибао», 1983. XII. 28

19. «Жэньминь жибао», 1983. XII. 28

НЕКОТОРЫЕ АСПЕКТЫ ЭКОНОМИЧЕСКОЙ ПОЛИТИКИ РУКОВОДСТВА КНР В НАЦИОНАЛЬНЫХ РАЙОНАХ

(1979—1984 гг.)

(Резюме)

В статье рассматриваются некоторые важнейшие аспекты экономической политики руководства КНР в национальных районах, в основном на примере автономных районов Внутренней Монголии, Синьцзяна, Тибета в указанный период.

С конца 70-х гг. руководство КНР стало подчеркивать необходимость «Соединения многочисленного населения ханьской нации ее технического преимущества с обширной территорией национальных меньшинств и ее природными ресурсами». В статье на конкретных примерах раскрываются пути и методы осуществления «Экономико-технического сотрудничества» автономных районов Внутренней Монголии, Синьцзяна, Тибета с развитыми приморскими и центральными городами, провинциям КНР.

Автор статьи также рассматривает такие общие проблемы экономики национальных районов КНР, как отсталость транспортной системы и острая нехватка инженерно-технических кадров, которые самым пагубным образом сказываются на экономическом развитии автономных районов.

В целом, по мнению автора, хотя китайское руководство вынуждено было отказаться от слишком односторонней игнорирования специфических особенностей автономных районов, слепого копирования экономических методов китайских провинций, но его так называемая политика «Экономико-технического сотрудничества» автономных районов с развитыми провинциями КНР, направленная обеспечение быстро растущих потребностей лишь последних, может народов автономных районов Китая.